



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН С.ОДОНТУЯА ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас/Факс: (976-51) 26 75 33,  
Цахим шуудан: info@mojha.gov.mn,  
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2022.11.10 № 1/5738  
танай 2022.10.26-ны № 42 -т

**Асуулгын хариу хүргүүлэх  
тухай**

Танаас ирүүлсэн “Ажлын хэсгийн дүгнэлтийг тодруулах тухай” Монгол Улсын Их Хурлын гишүүний асуулттай танилцан дараах хариуг хүргүүлж байна.

1.2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуульд шүүхийн зөвшөөрөлтэйгөөр сэжигтнийг баривчлах хугацаа 72 цаг хүртэл байсныг 48 цаг хүртэл, шүүхийн зөвшөөрөлгүйгээр баривчлах хугацаа 48 цаг хүртэл байсныг 24 цаг хүртэл болгож 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд хугацааг богиносгон заасан.

Түүнчлэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүйгээр болон шүүхийн зөвшөөрөлтэйгөөр баривчлах зохицуулалтыг тусгайлан хуульчилсан.

Тухайлбал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт сэжигтнийг гэмт хэрэг үйлдэж байх үед, эсхүл үйлдсэн дор нь барьсан, хуульд заасан хойшлуулшгүй тохиолдолд, гэмт хэрэг үйлдсэн гэж гэрч, хохирогч шууд заасан, тухайн хүний хувцас, бие, орон байр, эд зүйл, тээврийн хэрэгсэлд гэмт хэргийн ул мөр илэрсэн зэрэг 4 тохиолдолд мөрдөгч сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүйгээр баривчлах зохицуулалттай.

Хуульд заасан хойшлуулшгүй тохиолдол буюу хүний амь нас, эд хөрөнгөд ноцтой хохирол учрах, сэжигтэн, яллагдагч оргон зайлах, хэргийн ул мөр, эд мөрийн баримт устах, зөөвөрлөх нуун далдлах, үрэгдэх бодит аюул байгаа тохиолдолд шүүхийн зөвшөөрөлгүйгээр баривчилна.

Гэхдээ сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүйгээр баривчлах ажиллагаа прокурорын хяналт дор явагддаг. Хүний эрх, эрх чөлөөг хангаж, мөрдөн шалгах ажиллагааны явцад хуулийг нэг мөр хэрэгжүүлэх зорилгоор Улсын ерөнхий прокурорын тушаалаар “Жижүүрийн прокурор ажиллуулах журам”-ыг баталсан байх ба энэ журмын дагуу сэжигтнийг хойшлуулшгүй тохиолдолд баривчлах ажиллагаанд прокурор хяналт тавин ажиллаж байна.

Шүүхийн зөвшөөрөлгүйгээр баривчилсан тохиолдолд даруй прокурорт мэдэгдэж, прокурор шийдвэрийг шүүхэд даруй хүргүүлэх бөгөөд шүүх 24 цагийн

151614641

дотор шийдвэрлэх, энэ хугацаанд прокурор сэжигтэнд эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах мөрдөгчийн саналыг үндэслэлтэй гэж үзвэл саналыг хүлээн авснаас хойш 6 цагийн дотор баривчилсан сэжигтэнд эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах эсэхийг шийдвэрлэдэг.

Харин хууль бусаар баривчлагдсан сэжигтнийг прокурор даруй суллахаар мөн хууль заасан болно.

Сэжигтнийг хойшлуулшгүй баривчилсан тохиолдлын мөрдөн шалгах чиг үүрэг бүхий байгууллага (тагнуулын байгууллага, цагдаагийн байгууллага, авлигатай тэмцэх байгууллага)-ын 3 жилийн мэдээллээс үзэхэд:

д/д	Он	Нийт баривчилсан	Үүнээс Цагдаагийн байгууллага		Шүүхийн зөвшөөрөлгүй	Шүүхийн зөвшөөрөлтэй	Шүүхийн зөвшөөрөлгүй баривчилсан хэдий үргэлжлүүлэн цагдан хоригдсон	Нийт гэмт хэрэгт эзлэх хувь
			Нийт шалгасан хэрэг	Үүнээс баривчилсан				
1.	2020	1101	74698	1087	1087	14	638 буюу 57,9 %	1,4%
2.	2021	908	58132	878	878	30	524 буюу 57,7 %	1,5%
3.	2022	867	59235	780	780	87	448 буюу 51.6 %	1,3%

Цагдаагийн байгууллагын мөрдөгч сүүлийн 3 жилийн байдлаар тодорхой төрлийн буюу Эрүүгийн хуулийн хүний амьд явахын эрхийн эсрэг гэмт хэрэгт 115, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт 151 болон бусад 11.7 дугаар зүйл /Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх/, 12.1 дүгээр зүйл /Хүчиндэх/, 13.1 дүгээр зүйл /Хүн худалдаалах/, 17.1 дүгээр зүйл /Хулгайлах/, 17.2 дугаар зүйл /Дээрэмдэх/ зэрэг гэмт хэргүүдэд шүүхийн зөвшөөрөлгүй сэжигтнийг хойшлуулшгүйгээр баривчлах ажиллагааг явуулсан байна.

2.Төрийн албаны тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.2 дахь хэсэгт “Төрийн жинхэнэ албан хаагчийг албан тушаал дэвшүүлэх, цалин хөлсийг өөрчлөх, цол, зэрэг дэв олгох, урамшуулах, зохих шатны сургалтад хамруулах, албан тушаал бууруулах, хариуцлага хүлээлгэх асуудлыг түүний ажлын гүйцэтгэл, үр дүнг үндэслэн шийдвэрлэнэ.” гэж, 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсэгт “Төрийн жинхэнэ албан хаагч хууль тогтоомж болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж жил бүрийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийн хооронд хэрэгжүүлнэ.” гэж тус тус хуульчилсан.

Түүнчлэн Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид мөнгө урамшуулал олгох журам”-ын 2.1-д “Хуульд өөрөөр заагаагүй

бол улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн сахилга ёс зүйн зөрчил гаргаагүй албан хаагчид олгоно.” гэж, 2.2-т “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна.” гэж тус тус заасан.

Иймд Цагдаа, дотоодын цэргийн байгууллага Төрийн албаны тухай хууль, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ыг баримтлан албан хаагчдын ажлын үр дүнг үнэлж дүгнэн, хууль тогтоомжид заасан дээрх урамшуулал олгодог бөгөөд сэжигтэн, яллагдагчийг олноор баривчилсан, цагдан хорьсон нь мөрдөгчийн ажлыг дүгнэх шалгуур үзүүлэлт болж, цалин урамшуулал олгох үндэслэл болдоггүй.

3.Хууль зүй, дотоод хэргийн яамнаас санаачлан боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлж, УИХ-аас буцаасан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд сэжигтнийг баривчлах, яллагдагчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг авахад практикт амралтын өдрүүд тохиоход шүүхээр шийдвэрлүүлэхэд хүндрэл үүсэж, үүнээс улбаатай ялангуяа сэжигтнийг баривчлах хугацаа хэтэрч байгаа тохиолдол гарч болзошгүй байгаатай холбогдуулан энэ асуудлыг шийдвэрлэх үүднээс шүүхийн зөвшөөрлийг амралтын болон бүх нийтээр амрах өдрүүдэд авч хэрэгжүүлэх буюу 24 цагийн шүүх ажиллах эрх зүйн үндсийг бүрдүүлэх зохицуулалтыг тусгасан байсан.

Ийнхүү шүүхийн үйл ажиллагаа тасралтгүй явагдсанаар дээрх учирч байгаа хүндрэл бэрхшээл арилж, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт шуурхай хэрэгжих эрх зүйн орчин улам бүр боловсронгуй болно.

4.Монгол Улсын Үндсэн хуулийн Арвандолдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтад Монгол Улсын иргэн шударга, хүнлэг ёсыг эрхэмлэн хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх үндсэн үүрэгтэй.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.1 дэх заалтад “Монгол Улсын иргэн бусдын нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хохироохгүй байх, өөрийн үзэл бодлыг илэрхийлэхдээ бусдын нэр төр, алдар хүндэд хүндэтгэлтэй хандах, гэмт хэрэг, зөрчилд бусдыг өдөөн хатгахгүй, олон нийтийн аюулгүй байдал, нийтийн хэв журмыг гажуудуулах үйлдэл гаргахгүй байх үүрэгтэй.” гэж заасан. Харин Зөрчлийн тухай хуулийн 5.9 дүгээр зүйлд Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан үүргээ биелүүлээгүй үйлдлийг зөрчилд тооцон шийтгэл оногдуулахаар заасан.

Түүнчлэн Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Улс орны буюу тодорхой нутаг дэвсгэрийн хэмжээнд онц болон дайны байдал зарласан, гамшиг болон аюул тохиолдсон бол тухайн нутаг дэвсгэрт уг шалгаан арилтал жагсаал цуглаан хийхийг хориглоно.” гэж, 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт гудамж, талбайд жагсаалт, цуглаан хийх тухай мэдэгдлийг сум, дүүргийн Засаг даргад өгч бүртгүүлэхээр заасан.

Монгол Улсад 2020 онд 237, 2021 онд 178 удаагийн жагсаал, цуглааныг иргэд, олон нийтийн байгууллагаас Монгол Улсын Үндсэн хуульд заасан эрх, эрх чөлөөгөө



эдэлж, зохион байгуулж, цагдаагийн байгууллага хуульд заасан үүргийн хүрээнд уул ажиллагааг болон оролцогчдыг аливаа гэмт халдлагаас хамгаалах, олон нийтийн хэв журмыг хамгаалах ажиллагааг явуулсан байна.

Монгол Улсын Засгийн газраас Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулаад байгаа бөгөөд хүчин төгөлдөр мөрдөж байгаа Зөрчлийн тухай хуульд “хуулиар хориглосон”, “журамд заасныг зөрчсөн”, “үүргээ биелүүлээгүй” зэрэг хэт ерөнхий байдлаар заасан зөрчлийн үйлдлүүдийг тодорхой болгох, зөрчилд тооцох үйлдлүүдийн хүрээ хязгаарыг багасгах замаар иргэн, хуулийн этгээдэд учруулах хүндрэл чирэгдлийг арилгахад анхаарсан болно.

Энэ хүрээнд Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан үүргээ биелүүлээгүй бол” гэсэн ерөнхий заалтыг өөрчилж, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг үндэслэн хуулийн этгээдэд хамаарал бүхий тодорхой 4 үйлдлийг зөрчилд тооцохоор тусгаад байна.

Энэ нь Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар хүлээсэн үүргээ зөрчсөн үндэслэлээр шийтгэл оногдуулах нь иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хязгаарлах үндэслэл болж байгааг өөрчлөхөд дэвшилтэд алхам болно гэж үзэж байна.

5.Цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг боловсронгуй болгох зорилгоор Цагдаагийн албаны тухай хуульд холбогдох өөрчлөлтийг оруулах хуулийн төслийг боловсруулах, түүнчлэн иргэдийн тайван жагсаал, цуглаан хийх иргэдийн Үндсэн хуулиар олгогдсон эрх чөлөөг баталгаажуулах, жагсаал цуглаан хийх журмыг тогтоох, уул арга хэмжээний үед нийгмийн хэв журам, иргэдийн аюулгүй байдлыг хангах, иргэний эрхийг зөрчихгүй байхтай холбогдсон харилцааг зохицуулсан Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахаар ажиллаж байна.

